



УЛААНБААТАР ХИВС ХК

**“УЛААНБААТАР ХИВС” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН 2019 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

Улаанбаатар хот.

2019.04.11.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ !

Монгол улсын Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу “Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг 2019 оны 4-р сарын 11-ний \Пүрэв гариг\өдрийн 11.00 цагт компанийн хурлын танхимд хийнэ.

Хувьцаа эзэмшигч та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурал зохион байгуулах комисс

Утас: 342559., 80129061., 99186624.,

Факс : 343311

Э-мэйл : ubcarpet@gmail.com., tsravdan@yahoo.com

Web site: www.mongolia-carpet.mn

Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүн, 2019 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай зорилт
2. “Улаанбаатар хивс” ХК-ийн санхүүгийн тайлан аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
3. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2019 оны төсөв батлах тухай

Хурлын дотоод журам

1. Хурлын ирцийг бүртгэж, мэдээлэх -20 минут /10.40-11.00/
2. Хурал нээж, хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга нарыг сонгох- 5 минут
3. Хурлын хэлэлцэх асуудал, дотоод журмыг батлуулах – 5 минут
- Хурлын тэргүүлэгчид
4. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүн, 2019 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай зорилт - 20 минут
- Илтгэгч ТУЗ-ийн дарга Ц.Зоригт
5. “Улаанбаатар хивс” ХК-ийн санхүүгийн тайлан ба аудитын хорооны дүгнэлтийн тухай. - 10 минут. Компанийн ерөнхий ня-бо
6. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2019 оны зардлын төсөв батлах тухай
- 10 минут. Хурлын тэргүүлэгчид
7. Хэлэлцсэн асуудлын талаархи санал, шүүмжлэл / Хүн тус бүрд 5 минут/ -
- Цаг тогтоохгүй
Хурлын Тэргүүлэгчид
- 10/ Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг танилцуулах
- 30 минут.
- Тооллогын комисс
- 11/ Хурлын шийдвэрийн төслийг батлуулж, хурал хаах
- 10 минут
Хурлын тэргүүлэгчид

Хурлыг 4-р сарын 11-ны өдөр 11.00 – 13.00 цагт багтааж хийхээр төлөвлөсөн.



УЛААНБААТАР ХИВС ХК

“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын машины аргаар хивс нэхэх анхны үйлдвэр болох “Улаанбаатар хивс” ХК нь 1971 онд БНАГУ-ын /хуучин нэрээр/ техник эдийн засгийн тусламжтайгаар баригдаж, жилд 2 ээлжээр 350.0 мянган м² хивс үйлдвэрлэх хүчин чадалтай ашиглалтанд орсон бөгөөд 1978 онд бүрэн хүчин чадлынхаа хэмжээнд хүрч ажилласан. Одоогоор 2 ээлжээр жилд 150 мянган м² хивс үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. Тус компани нь 1992 онд 100 хувь хувьчлагдаж, хувьцаат компани болсон ба одоо 913 хувьцаа эзэмшигчидтэй.

Компани нь одоогийн байдлаар 120 орчим ажилчидтай, хонины ноосыг угааж, угаасан ноосоор ээрмэл бэлтгэн төрөл бүрийн өнгөөр будаж Улаанбаатар, Алтанбулаг, Онон, Отгонтэнгэр, Саян, Алтай нэртэй цэвэр ноосон хивс үйлдвэрлэж дотоод, гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Машинт хивс үйлдвэрлэхийн зэрэгцээ уламжлалт гар аргаар захиалга хивс нэхэж байна.

“Улаанбаатар хивс” ХК-ийн бэлэгдлийн тэмдэг нь Алтайн уулсын Ноён уулын булшнаас олдсон дэлхийн хамгийн анхны хивсэн дээрхи буга барьж буй хангарьд шувууны дүрслэл юм. Энэ тэмдгийг хэрэглэх онцгой эрхийг 1992 онд авсан.

“Улаанбаатар хивс” ХК-ийн удирдлагын тогтолцоо:

- *Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал*
- *Төлөөлөн удирдах зөвлөл*
- *Гүйцэтгэх удирдлага*
- *Компанийн дүрэм, дотоод журам, компанийн засаглалын кодекс, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, албадын удирдамж, заавар ажлын байрны тодорхойлолт зэрэг удирдлагын баримт бичгүүд байна.*

ХАМТЫН ХӨГЖИЛД СЭТГЭЛ, ЗҮТГЭЛ, БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГЭЭР ХҮРЦГЭЭЕ.

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тухай

Өнгөрсөн хугацаанд ТУЗ 3 удаа хуралдаж цаг үеийн чухал шаардлагатай 9 асуудлыг хэлэлцэж холбогдох чиглэлээр 8 тогтоол гарган шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, хороодын гишүүд шинээр сонгогдож бусад цаг үеийн асуудлыг тухай бүрд нь хэлэлцэн шийдвэрлэж ирсэн. ТУЗ-ийн зүгээс үйлдвэрийн жигд ажиллагааг сайжруулж, нөөц хүч, бололцоог дайчлан ажиллах, зардал бууруулах гм үндсэн чиглэлд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж, ТУЗ-ийн даргын хувьд үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэл, өдөр тутмын ажилд биечлэн оролцож, гүйцэтгэх удирдлагатай хамтдаа давхардсан тоогоор 70 шахуу тулгамдсан асуудлуудыг газар дээр нь хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.

Тус компани нь 1992 онд 100 хувь хувьчлагдаж, хувьцаат компани болсон ба 2019.03.18-ны бүртгэлийн өдрөөр үнэт цаасны 50 БДК-ийн 913 хувьцаа эзэмшигчидтэй болж, сүүлийн 52 долоо хоногийн дундаж үнийн хувьд компанийн нэгж хувьцааны үнэ 9000-17500 төгрөгийн хооронд хэлбэлзэж, компанийн зах зээлийн үнэлгээ 6,4 тэрбум төгрөг болсон. Нийт хувьцааны 94 хувь нь 6 хувьцаа эзэмшигчид төвлөрдөг ба 11 гадаадын иргэд, ААН-үүд эзэмшдэг. Компанийн хувьцааны дундаж ханш сүүлийн 10 жилд 7,5 дахин өсөж, энэ оны 3-р сарын 18-ны байдлаар 15800 төгрөгийн хаалтын ханштай байна.\судалгааг хавсаргав\.

Бид компанийн тухай, үнэт цаасны тухай хууль, журмыг мөрдөж, МХБ болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагуудтай зохих ёсоор хамтран ажиллаж, холбогдох гэрээ, мэдээ, тайлан, төлбөр тооцоог зохих журмын хугацаанд нь барагдуулж ажилладаг.




“УЛААНБААТАР ХИВС” ХК

Улаанбаатар хивс ХК (UBH)

15800 ↔ 0 (0.00%)

Өмнөх өдрийн хаалт:	15,800.00	Өдрийн хязгаар:	0.00 - 0.00
Нээлтийн ханш:	0.00	Арилжигдсан ширхэг:	0
Хаалтын ханш:	N/A	Арилжааны үнийн дүн:	0.00
Тухайн өдрийн VWAР:	0.00	Хэлцлийн тоо:	0
Авах дээд үнэ:	0.00 x 0	52 долоо хоног:	9,000.00 - 17,500.00
Зарах доод үнэ:	0.00 x 0	Зах зээлийн үнэлгээ:	6,396,298,200.00
Нийт хувьцааны тоо ширхэг:	404,829	ISIN:	MN00UBH00079
Гаргасан хувьцааны тоо ширхэг:	404,829		



Тайлант онд Улаанбаатар хивс ХК-ийн хамт олон 60907 м2 хивс үйлдвэрлэж төлөвлөгөөгөө 101%-иар биелүүлсэн нь өнгөрсөн оноос 10901 м2 хивс буюу 21,8 хувиар, 54143м2 хивс борлуулсан нь үнийн дүнгээр 3706,7сая төгрөгт хүрч урьд оноос 27,6 хувиар буюу 803,0 сая төгрөгөөр өсөж 235,6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

Тус компанийн

- **Ээрэх цехэд** 132563 кг угаасан ноос оруулж, 85923 кг 15/3-ын ноосон утас үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оноос 24971 кг-аар өссөн ба төлөвлөгөөний биелэлт 113,1%, тоног төхөөрөмжийн ашиглалт 96,2% байв.
- **Будгийн цех** 27 өнгөөр 102774 кг ээрсэн утсыг будаж, шилжүүлэн ороож, нэхэх цехэд шилжүүлсэн нь өнгөрсөн оныхоос 22216 кг-аар өсчээ. Төлөвлөгөөний биелэлт 113% , тоног төхөөрөмжийн ашиглалт 56,8%-тай байв.
- **Нэхэх цех** нийт 61426 м2 хивс нэхсэнийг нэр төрлөөр нь харуулбал:
Алтанбулаг хивс 43378
Алтан-Өргөө хивс 4798,5
Улаанбаатар хивс 1178
Саян хивс 12071,5 м2 тус тус байна. Цехийн төлөвлөгөөний биелэлт 101,9% , тоног төхөөрөмжийн ашиглалт 94,4% байв.
- **Нөхөн засах гүйцэтгэх цех** 2018 онд 60906,7м2 хивсийг гүйцэтгэн боловсруулж агуулахад тушаажээ. Төлөвлөгөөний биелэлт 101%, тоног төхөөрөмж ашиглалт 87,3%-тай байв.
2018 онд тус компаниас доорх үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- 2018-2019 оны ноос бэлтгэлийн ажлын хүрээнд өөрийн болон зээлийн хөрөнгөөр нийт 172,2 тн ноос 617,6 сая төгрөгөөр авч, ялган угаалгаж үйлдвэрлэлд оруулан ажиллаж байгаа нь 2019 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө биелүүлэхэд гол түлхэц болох юм.

- Гадны байгууллагууд болон хувь хүмүүсийн захиалгаар 4209,49 м2 буюу 312.3 сая төгрөгийн хивсийг захиалагчдын хүссэн өнгө загвар, тоо хэмжээгээр үйлдвэрлэсэн нь жилийн үйлдвэрлэлийн 8,4%-ийг бүрдүүлж байна.
- Алтанбулаг хивсээр-30, Саян хивсээр-62, шинэ загвар гаргаснаар загварын сонголт 92- ээр нэмэгдсэн байна.
- Бүтээгдэхүүний каталоги, хятад, орос, монгол хэл дээр брошюр хийлгэж, хулдаасан хэвлэл цаг тухайд нь бэлтгэгдэж хэрэглэж байв.
- БНХАУ болон гадаадын бусад улс орнуудад зохиогдсон 30 гаруй үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож 954 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ. Энэ нь нийт борлуулалтын 25,7%-ийг эзэлж байна.
- 2018 оны 9-р сард Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг дэхь Драгон төвийн салбараа УБИД-т шилжүүлснээр нийслэлд нийт 3 борлуулалтын цэг ажиллаж байна.
- Вэб хуудсыг шинэчлэн хийж бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, хямдрал, урамшуулалтай худалдааг цаг тухайд нь худалдан авагчдад мэдээлэх боллоо. Мөн веб сайтаар дамжуулан гарах боломжтой бүх загварыг харуулах болсон ба худалдан авагчид мэдээлэл авч, тав тухтай сонголт хийхээс гадна бэлэн байхгүй байгаа ч гэсэн өөрийн сонгосон загвараа захиалгаар хийлгэж авах боломжтой.
- Компанийн Facebook page хуудас 15000 дагагчидтай болж шинэ загвар, хямдрал урамшуулалтай худалдааны талаарх мэдээллийг тогтмол оруулж байгаа ба цаашид ч фэйсбүүкээр хандах худалдан авагчдын хандлага нэмэгдэх хандлагатай байгаа. Мөн цаг тухай бүрт мэдээлэл өгч ажиллаж байна.
- Цагаан сар, Наурыз, Наадам, Хурим найр, Хаврын хямдрал, Нийслэлийн ойн баяр, Шинэ жилийн баяр зэрэг хямдралууд зарлаж, борлуулалтаа идэвхжүүлэв.
- Компанийн дэргэдэх нэрийн барааны болон УБИД дахь дэлгүүрүүдийн тохижилт, засварын ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн нь борлуулалтанд эерэгээр нөлөөлсөн гэж үзэж байна.
- Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих төсөл”-д сонгогдон оролцож, төслийн хүрээнд “Экспорт хөгжлийн төлөвлөгөө” боловсруулан хэрэгжүүлж байна. Энэхүү төлөвлөгөөний дагуу зорилтот зах зээл болох БНХАУ-ын ӨМӨЗО-ын Хөх хот, Ордос хот, Баяннуур аймаг, Шилийн гол аймаг, Алаша аймгуудын хивсний зах зээлийн томоохон судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.
- Нэхэх цехийн 3 метр өргөнтэй 1 нэхэх машинд Такемура электрон призма худалдан авч суурилуулсан.
- Нэхэх 2 машинд их засвар хийж, цаашдын найдвартай ажиллагааг хангав.
- Технологийн хаягдал түүхий эдийн ашиглалтыг сайжруулах зорилгоор, таараар тор-цүнх, уул болон гологдол хивсээр гэрийн тапочки зэргийг хийж худалдаанд гаргасан.
- Компанийн бичил орчны хэвийн ажиллагааг хангах зорилгоор сантехникийн шугам хоолойн хэсэгчилсэн засваруудыг хийсний дотор компанийн гадна оршдог, уур ба халаалтын 95 метр шугам солив. Эдгээрийн үр дүнд зэрэх цехийн бичил орчны доголдол бүрэн арилав.
- Компанийн оффисын халаалтын узелийг өөрчлөн ялтаст бойлор тавьсан ба үйлдвэрийн цехүүдийн агааржуулалт, халаалт, чийгшүүлэлтийг сайжруулах зорилгоор илүүдэл шугам, хонгилуудыг хаах, ажиллахаа больсон тоноглол, байгууламжуудыг засварлах, холбох ажлуудыг хийснээр цехүүдийн чийгшилтийг 60-65%, халаалтын хэмийг 15-18 градуст барьж байна.
- Уулзалтын өрөөг шинээр тохижуулан ашиглалтанд оруулав.
- Цехүүдийн хуучин гэрлийг сольж эрчим хүч хэмнэлттэй лед гэрлийг суурилуулж эхлэсэн ба зэрэх цехийн гэрлийг үндсэнд нь лед гэрэл болгов.
- Будгийн цехийн тааз хананд засвар хийж шинэчлэлээ.
- Нягтлан бодох бүртгэлийн шинэ программ нэвтрүүлсэнээр бараа бүтээгдэхүүний бүртгэлд бар кодыг нэвтрүүлж, үйлдвэрлэл, борлуулалтын уялдааг сайжруулах бололцоотой болов.

Цаашид үйлдвэрлэлийн жигд ажиллагаа, ажиллах хүчний сургалт нөхөн хангалтын оновчтой бодлого явуулан, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтыг сайжруулахад анхааран ажиллана. Үүнд:

- Ноосны хялгас ялгах тасгийн үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллуулсанаар хялгасыг ялгасан ноос болон ийм төрлийн ноосоор хийсэн нарийн номерын утасны үйлдвэрлэлийг зохион байгуулна.

- Бүтээгдэхүүний зураг дизайн, чанарыг сайжруулж ажиллах ба экспортын борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд гадаад орнуудад зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаанд оролцож цаашид байнгын зах зээлтэй болж хамтран ажиллах түнш олоход анхааран ажиллах болно.

2019 оны үйл ажиллагааны үндсэн зорилт, үзүүлэлт

Бид энэ онд 2018 оны хүрсэн түвшин , зах зээлийн хандлага, эдийн засгийн нөхцөл байдал, инфляци болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тооцон үзэж доорх үндсэн зорилтуудыг тавин ажиллаж байна.

Үүнд:

1.Үйлдвэрлэлт	64200 м2 хивс
2.Борлуулалт	3900сая төг
3.Хөрөнгө оруулалт	500сая төгрөг
4.Цэвэр ашиг	270 сая төгрөг
5.Үйлдвэрлэлийн нэгж өртөг	60400 төгрөг

Манай компанийн хамт олон үйлдвэрлэл технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, зураг дизайн, чанар, сав баглаа боодлыг сайжруулж, гадаад дотоод харилцаа, борлуулалтын сүлжээгээ өргөтгөхөд ихээхэн анхаарал тавьж 2019 оны үндсэн зорилтуудаа хэрэгжүүлэн ажиллах болно.

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхнийг үндэсний ууган үйлвэрүүдийн нэг болох “Улаанбаатар хивс” ХК-иа дэмжиж, тавьсан зорилтуудаа биелүүлэхэд нэг санаагаар хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

RSA

“РЕЛАЭНС СЕКЮРИТИЗ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.
Нисэх - 60/1 Ү- 11.
Утас: 99813174, 99119456
E-mail: jtsetsegma@yahoo.com

УЛААНБААТАР ХИВС ХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ТАНАА

№
Танай 2019.03.29 -ны № 019/87 -т

АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “ Улаанбаатар хивс” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан тэнцэл, үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Улаанбаатар хивс”ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүү байдлын тайлан тайлан тэнцэл, үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бодиттой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно . Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцж ажиллах , мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг .

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуулыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд , тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав .

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай , зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Бид аудитын нягтлах ажыг хийх явцдаа доорхи АОУС-уудыг мөрдөж ажиллалаа.

Үүнд : АОУС500, АОУС510 ,АОУС530

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүтээх үүрэг , хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, толилуулах нь компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх , мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан , алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх , толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох , хэрэгжүүлэх , тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүтээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын зүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч ,Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

(Энэхүү тайлан нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно)


ЗАХИРАЛ

Ж.ЦЭЦЭГМАА
2019.03.29 № 019/894

"УЛААНБААТАР ХИВС" ХК
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
 2018 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	ХӨРӨНГӨ	
	2017.12.31	(Төгрөгөөр) 2018.12.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	103,490,895.46	22,383,423.36
Дансны авлага	157,891,357.94	23,976,180.27
Татвар, НДШ -ийн авлага		
Бусад авлага	11,882,754.14	13,423,920.98
Бусад эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	1,831,922,535.63	2,097,511,638.88
Урьдилж төлсөн зардал тооцоо	945,868,797.94	1,120,186,684.45
Хангамжийн материал		
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,051,056,341.11	3,277,481,847.94
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	6,147,184,953.69	5,927,892,164.42
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,920,000.00	1,920,000.00
ХО-ын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Хайгуул үнэлгээний хөрөнгө		
Биет бус хөрөнгө	4,600,000.57	1,266,367.27
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,153,704,954.26	5,931,078,531.69
НИЙТ ХӨРӨНГӨ	9,204,761,295.37	9,208,560,379.63

АУДИТОР



Б.ХАНДСҮРЭН

"УЛААНБААТАР ХИВС" ХК
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
 2018 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ

	2017.12.31	2018.12.31
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны өглөг	286,581,101.43	167,068,376.22
Татварын өглөг	238,442,385.91	191,919,175.24
Нийгмийн даатгалын өглөг	40,431,295.83	15,158,479.93
Цалингийн өглөг	31,337,202.86	36,063,424.00
Урьдчилж орсон орлого	42,026,136.32	27,380,738.31
Бусад богино хугацаат өр төлбөр		
Хүүгийн өглөг	484,665,816.80	528,599,776.56
Богино хугацаат зээл	1,109,495,500.00	1,205,291,500.00
Ногдол ашгийн өглөг	18,365,295.00	23,780,460.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,251,344,734.15	2,195,261,930.26
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат өр	653,818,181.84	518,545,454.60
Урт хугацаат өр төлбөрийн дүн	653,818,181.84	518,545,454.60
Өр төлбөрийн дүн	2,905,162,915.99	2,713,807,384.86
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ДҮН		
Өмч:Төрийн		
Хувийн		
Хувьцаат	40,482,900.00	40,482,900.00
Халаасны хувьцаа	-22,400.00	-22,400.00
Нэмж төлөгдсөн капитал	34,184,059.26	34,184,059.26
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,707,643,027.30	6,707,643,027.30
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-482,689,207.18	-287,534,591.79
Өмнөх ашиг (алдагдал)	-699,447,615.06	-482,689,207.18
Тайлант ашиг (алдагдал)	216,758,407.88	195,154,615.39
Хувьцаа эзэмшигчдийн дүн	6,299,598,379.38	6,494,752,994.77
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,204,761,295.37	9,208,560,379.63

АУДИТОР  Б.ХАНДСҮРЭН

**"УЛААНБААТАР ХИВС" ХК
АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН**

(Төгрөгөөр)

	2017.12.31	2018.12.31
Цэвэр борлуулалтын орлого	2,903,770,454.67	3,706,764,018.67
Борлуулалтын өртөг	2,410,940,495.21	2,930,980,589.32
Нийт ашиг	492,829,959.46	775,783,429.4
Хүүгийн орлого	1,962,182.9	1,246,218.70
Түрээсийн орлого	334,468,904.0	352,827,569.99
Бусад орлого	393,882,381.9	482,873,135.3
Борлуулалт маркетингийн зардал	486,920,641.0	505,690,049.0
Ерөнхий ба удирдлагын зардал	153,083,705.4	152,218,988.4
Санхүүгийн зардал		
Бусад зардал	346,174,986.8	559,980,866.11
Бусад ашиг/алдагдал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	34,018,862.2	-119,717,698.37
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз		
Татварын өмнөх цэвэр ашиг (алдагдал)	270,982,957.3	275,122,751.4
	23,862,374.4	39,485,236.00
ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	247,120,582.9	235,637,515.39
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	610.43	582.07

АУДИТОР



Б.ХАНДСҮРЭН

"УЛААНБААТАР ХИВС" ХК
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН
 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үе

(Төгрөгөөр)

Агуула	Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Дүн
Эхний үлдэгдэл	40,482,900.00	(22,400.00)	34,184,059.26	6,707,643,027.30	(482,689,207.18)	6,299,598,379.38
НББ-ийн бодлогын өөрчлөлт						-
Заруулсан үлдэгдэл	40,482,900.00	(22,400.00)	34,184,059.26	6,707,643,027.30	(482,689,207.18)	6,299,598,379.38
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт						-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралт						-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц						-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз (гарз)						-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					235,637,515.39	235,637,515.39
Бусад дэлгэрэнгүй орлого						-
Өмчийн өөрчлөлт						-
Зарласан ногдол ашиг					40,482,900.00	40,482,900.00
2017 оны 12-р сарын	40,482,900.00	(22,400.00)	34,184,059.26	6,707,643,027.30	(287,534,591.79)	6,494,752,994.77



АУДИТОР

Б.ХАНДСҮРЭН


"УЛААНБААТАР ХИВС" ХК
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үе

	2017.12.31	(Төгрөгөөр) 2018.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</u>	<u>4,102,272,324.58</u>	<u>5,005,034,814.65</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,595,069,759.08	4,454,526,187.10
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан		
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	507,202,565.50	550,508,627.55
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	<u>3,996,881,889.54</u>	<u>5,076,381,321.84</u>
Ажиллагчдад олгосон мөнгө	711,828,383.00	795,789,158.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	229,000,000.00	235,000,000.00
Бараа, материал худалдан авахад төлсөн мөнгө	1,408,966,828.05	1,761,272,800.67
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	461,715,844.73	1,368,925,609.21
Түлш шатахуун, тээвэр, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	80,058,834.87	35,222,736.19
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө		
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	78,843,613.73	
Татварын байгууллагад төлсөн мөнгө	422,419,447.90	433,728,732.69
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Бусад мөнгөн зарлага	604,048,937.26	446,442,285.08
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	105,390,435.04	(71,346,507.19)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,000,000.00	
Хүлээн авсан хүүний орлого	1,962,182.91	1,246,218.70
Хүлээн авсан ногдол ашиг		
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	83,081,710.00	
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	95,268,700.91	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	141,144,768.25	
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(150,369,576.25)	1,246,218.70
САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
Мөнгөн орлогын дүн	400,000,000.00	500,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	400,000,000.00	500,000,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Урт хугацаат санхүүжилт		
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал		
Бусад мөнгөн зарлага		
Мөнгөн зарлагын дүн	315,262,280.66	511,019,445.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	304,181,818.16	480,000,000.00
Төлсөн ногдол ашиг	11,080,462.50	31,019,445.00
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	84,737,719.34	-11,019,445.00
Валютын ханшийн зөрүү	1,017,954.16	12,261.39
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	40,776,532.29	-81,107,472.10
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	62,714,363.17	103,490,895.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	103,490,895.46	22,383,423.36

АУДИТОР



Б.ХАНДСҮРЭН



Хувьцаа эзэмшигчдийн хурлын
шийдвэрийн төслүүд.

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Дугаар № 01 /2019.

2019.04.11.

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны
үр дүнгийн тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлаар тус компанийн 2018 оны үйл ажиллагааны үр дүн, хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын дүнг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнг тайлангаар хүлээн зөвшөөрч цаашид компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр тавьж буй үндсэн зорилтуудыг 2019 онд үр дүнтэй үргэлжлүүлэн ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ДАРГА : **Ё.ЭНХТӨР**

ГИШҮҮД :

.

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Дугаар № 02 /2019

2019.04.11.

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны
үндсэн үзүүлэлтийг батлах тухай

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцсэн асуудал, 2019 оны үйлдвэрлэл, үйл ажиллагаа, бизнесийн төлөвлөгөөний зорилт, үзүүлэлтүүдийн талаархи санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ :**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож баталсугай. Үүнд :

- Үйлдвэрлэлт	64200 м2 хивс
- Борлуулалт	3900 сая ₮.
- Хөрөнгө оруулалт	500 сая төгрөг
- Цэвэр ашиг	270 сая төгрөг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	60400 төгрөг

2. Компанийн төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхийн тулд компанийн техник, эдийн засгийн хүч, нөөц бололцоог үр ашигтайгаар удирдан зохион байгуулж ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, нийт ажиллагчдад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ДАРГА : **Ё.ЭНХТӨР**

ГИШҮҮД :

.

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Дугаар № 03 /2019

2019.04.11.

Улаанбаатар хот

ТУЗ-ийн үйл ажиллагааны
зардлын төсөв батлах тухай

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцсэн асуудал, санал, шүүмжлэл, хэлэлцсэн асуудлын талаархи тооллогын комиссын санал хураалтын дүнг үндэслэн

ТОГТООХ НЬ :

1. Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын 2019 оны үйл ажиллагааны зардлыг 12,5 сая төгрөгөөр Хавсралт 01-ийн дагуу баталсугай.
2. Шаардагдах хөрөнгийг цаг тухайд нь гаргаж, холбогдох ажлын нөхцөлөөр хангаж ажиллахыг компанийн гүйцэтгэх удирдлага, санхүүд даалгасугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ДАРГА : **Ё.ЭНХТӨР**

ГИШҮҮД :

.

ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны
зардлын төсөв.

№	Зардлын товч утга	Нийт дүн /₮
1	Цалин, урамшуулал	6800000
2	Тээвэр, шатахуун, сэлбэг	400000
3	Бичиг хэрэгсэл, үйлчилгээний зардал	800000
4	Хэвлэл, холбоо, интернетын зардал	2000000
5	Хянан шалгалт, томилолтын зардал	1500000
6	Бусад сургалт, аттестачлал	1000000
	Д ү н	12500000

**“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2019 оны ээлжит хурлын саналын хуудас**

Компанийн нэр : **“Улаанбаатар хивс” ХК**
Хурал хуралдах газар, өдөр, цаг : **“Улаанбаатар хивс” ХК-ийн хурлын танхим,
2019.04.11-ний өдөр,
11.00 цаг**

Хувьцаа эзэмшигчийн овог : _____ нэр : _____
Регистрийн дугаар : _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл /доогуур нь зурах/ : _____ энгийн / давуу эрхийн.

Эзэмшиж буй хувьцааны тоо : _____ ширхэг.

Бүртгэгдсэн : Брокерийн компанийн нэр, код : _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар : _____

Хурлын хэлэлцэн батлах асуудлууд:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүн, 2019 оны үндсэн зорилт, үзүүлэлтийг батлах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2. “Улаанбаатар хивс” ХК-ийн санхүүгийн тайлан аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны 2019 оны зардлын төсөв батлах <input type="text" value="12,5 сая ₮"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хурлаас гарах шийдвэрийг зөвшөөрсөн буюу татгалзсан товч утга :
.....
.....
.....

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг :
2019 оны 4 дүгээр сарын ... өдөр.

Саналын хуудсыг бөглөх санамж

1. Хувьцаа эзэмшигч нь "Компанийн тухай хууль"-ийн 69.1-д заасны дагуу заавал биечлэн оролцох буюу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно. Хуралд оролцохоор ирэхдээ иргэний үнэмлэх, итгэмжлэлийг заавал авч ирнэ.
2. Хэрвээ саналын хуудсыг засварласан болон балласан, залруулга хийсэн, хоёрдмол утгатай бичигдсэн бол хуудас нь хүчингүйд тооцогдоно. Хуралд биеэр оролцогч нь саналын хуудсаа солих шаардлага гарвал хуралд оролцогч нарт биечлэн тайлбарлан танилцуулж саналын хуудсаа хайрцаганд хийхээс өмнө шинэ саналын хуудас авч болно.
3. Хэрэв та саналын хуудсаар оролцох бол саналын хуудсаа зохих ёсоор бөглөөд нотариатаар баталгаажуулан шуудангаар юмуу брокерийн пүүсээр дамжуулан компанид ирүүлж болно. Хэрвээ таны саналын хуудас хурлын ирцийн бүртгэл дууссанаас хойш буюу 11.00 цагаас хойш ирвэл ирц болон санал хураалтын дүнд оруулахгүй.
4. Хэрэв брокерийн пүүсийн ажилтан харилцагч хувьцаа эзэмшигчээ төлөөлж хуралд оролцох, санал өгөх эрхтэй бол нотариатаар батлуулсан зохих итгэмжлэлийг саналын хуудасны хамт компанийн хурал зохион байгуулах комисст биечлэн авч ирнэ.
5. Хэрэв Та харилцагч брокерийн компаниас саналын хуудсаа авсан бол түүнийгээ аван хуралд оролцож болно.
6. Саналын хуудасны асуудлуудад санал өгөхдөө арын дөрвөлжинд бичигдсэн хариултуудын зөвшөөрч буй хэсгээ дугуйлж санал өгнө. Хэрвээ таны өгөх саналтай бэлдсэн хариултууд тохирохгүй бол Та хурлаас гарах шийдвэрийг зөвшөөрсөн, татгалзсан товч тайлбарын хэсэгт саналаа бичиж болно.
7. ТУЗ-ийн гишүүдийн сонгуульд санал өгөхдөө хуулинд заагдсан кумулятив арга буюу Та өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа тоог 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү хэмжээний саналыг өгөх эрх эдлэнэ. ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгөх саналын тооны нийт нийлбэр нь таны хувьцааг 6-гаар үржүүлсэнтэй тэнцүү байх ба харин ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгөх саналын тооны нийлбэр нь таны хувьцааг 3-аар үржүүлсэнтэй тэнцүү байна. Та дээрхи аргаар тооцсон бүх саналаа 1 хүнд ч өгч болно.
8. Санал өгөх үед ойлгомжгүй зүйл гарвал хурлын тэргүүлэгчид болон хурал зохион байгуулагч нарт хандан асууж болно. Бусад тохиолдолд "Улаанбаатар хивс" ХК-иас 11-342559, 99186624 дугаарын утсаар лавлаж болно.

Т о о л л о г ы н к о м и с с